

## Мөнгөний тойм

2008 оны 12 дугаар сар

### 1. Үнэ

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2008 оны 12 дугаар сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх сартай харьцуулахад 0.04 хувь, оны эхнээс 22.1 хувиар өсчээ. Өнгөрсөн оны 8 дугаар сард хамгийн дээд түвшин 34.2 хувьд хүрч байсан жилийн инфляци буурч 22.1 хувь болов. Мөнгөний бодлогыг хатууруулсан явдал нь үүнд зохих нөлөө үзүүлсэн. Улаанбаатар хотын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувиар буурч, оны эхнээс 23.2 хувиар өссөн байна. Хэрэглээний үнийн индексийг тооцдог сагснаас мах, сүү, хүнсний ногооны төрлийн 29 барааг хасч тооцсон *суурь инфляци* өмнөх сараас 0.5 хувиар буурчээ.


Хүснэгт 1. Хэрэглээний барааны үнийн индекс /хувиар/

|  | Хувийн жин   | 2008-12      | 2008-12     |
|--|--------------|--------------|-------------|
|  |              | 2007-12      | 2008-11     |
| Хүнсний бараа, ундаа, ус                             | 41.08        | 124.5        | 99.4        |
| Согтууруулах ундаа, тамхи                            | 2.26         | 108.9        | 101.4       |
| Хувцас, бөс бараа, гутал                             | 12.38        | 126.1        | 99.9        |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш                       | 13.40        | 117.4        | 100.0       |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа                   | 4.30         | 114.6        | 99.8        |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ                       | 1.62         | 127.4        | 99.6        |
| Тээвэр   | 8.71         | 133.8        | 96.8        |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ              | 4.05         | 96.1         | 100.0       |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ          | 3.33         | 108.8        | 100.9       |
| Боловсролын үйлчилгээ                                | 4.15         | 137.6        | 100.0       |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ. | 1.72         | 134.4        | 100.1       |
| Бусад бараа үйлчилгээ                                | 3.0          | 115.6        | 100.7       |
| <b>Ерөнхий индекс</b>                                | <b>100.0</b> | <b>123.2</b> | <b>99.5</b> |

Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо, (Улаанбаатар хотын индекс)

Хэрэглээний үнийн индексээр тооцсон сарын инфляци Улаанбаатар хотод 2008 оны 12 дугаар сард 0.5 хувиар буурсан нь хэрэглээний барааны сагсанд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний бараа, ундаа, ус бүлгийн дүн 0.6 хувь, тээвэр бүлгийн дүн 3.2 хувиар буурснаас шалтгаалжээ.

Зураг1. Инфляци



Тайлант сард хувцас, бөс бараа, гутал, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ зэрэг бүлгүүдийн индекс 0.1-0.4 хувиар буурч, орон сууц, ус, цахилгаан, түлш, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээ бүлгүүдийн индекс тогтвортой байлаа. Бусад бүлгүүдийн индекс 0.1-1.4 хувиар өссөн байна.

Тухайлбал 1 кг хонины махны үнэ 0.7 хувь, үхрийн махных 2.2 хувь, гурил (дээд зэрэг) 2.3 хувь, төмс (дотоод) 2.3 хувь, лууван (дотоод) 8.5 хувиар тус тус хямдарсан нь хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 0.6 хувиар буурахад нөлөөлжээ. Мөн тээвэр бүлгийн индекс 3.2 хувиар буурсан 1 литр А-80 бензин 15.4 хувь, А-93 бензин 14.4 хувь, дизелийн түлшний үнэ 12.2 хувиар тус тус буурснаас шалтгаалжээ. Согтууруулах ундаа, тамхи бүлгийн дүн 1.4 хувиар өссөн нь дүнсэн тамхи 6.3 хувь, янжуур тамхи 4.4 хувиар тус тус өссөнөөс шалтгаалжээ.

## 2. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт<sup>1</sup> өмнөх оны мөн үеэс 2.5 хувь (59.8 тэрбум төгрөг)-аар буурч, өмнөх сараас 4.4 хувь (99.6 тэрбум төгрөг)-аар өсч 2341.4 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард бага мөнгө 20.5 хувь (112.3 тэрбум төгрөг)-аар нэмэгдсэн нь нийт мөнгөний өсөлтөд нөлөөлжээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд 2007 оны мөн үеийнхээс 58.8 нэгжээр саарсан байна. Энэ нь инфляцийн өсөлтөөс сэргийлэн Монголбанкнаас явуулсан мөнгөний хатуу бодлого, дэлхийн санхүүгийн хямралаас үүдэж гадаад валютын гадагшаа чиглэсэн урсгалын өсөлт зэргээс шалтгаалжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх оны мөн үеэс 11.8 хувь (43.1 тэрбум төгрөг), өмнөх сараас 23.0 хувь (76.3 тэрбум төгрөг)-аар тус тус өсч 407.2 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.


### 2.1 Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг эх үүсвэр талаас нь авч үзвэл, бараг мөнгө<sup>2</sup> 71.8 хувь (үүнд төгрөгийн хадгаламж 56.2 %, гадаад валютын хадгаламж 26.9%, гадаад валютын харилцах 16.9%), бага мөнгө<sup>3</sup> буюу М1 мөнгө 28.2 хувь (үүнд банкнаас гадуурх мөнгө 49.8%, төгрөгийн харилцах 50.2%) тус тус бүрдүүлж байна.

#### Бараг мөнгө

Бараг мөнгө нь тайлант сарын эцэст 1680.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх сарынхаас 0.7 хувь буюу 12.7 тэрбум төгрөгөөр багассан нь төгрөгийн хадгаламж 67.9 тэрбум төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Бараг мөнгөний өсөлт 2007 оны мөн үеэс 57.5 нэгжээр саарчээ.

Зураг 2. М1, М2, Бараг мөнгө (жилийн өөрчлөлт)



Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувь буюу 92.9 тэрбум төгрөг, өмнөх сараас 1.2 хувь буюу 17.5 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Нийт хадгаламжийн 67.6 хувь нь төгрөгийнх, 32.4 хувь нь валютын хадгаламж байна. Тайлант онд төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 15.2 хувь буюу 169.6 тэрбум төгрөг, өмнөх сараас 6.7 хувь буюу 67.9 тэрбум төгрөгөөр тус тус буурч 944.1 тэрбум төгрөгт, гадаад валютын хадгаламж өмнөх оны мөн үеэс 20.4 хувь буюу


<sup>1</sup> М2-мөнгөний нийлүүлэлт нь бараг мөнгө, М1 мөнгөний нийлбэр.

<sup>2</sup> Бараг мөнгө нь төгрөг болон валютын хадгаламж, валютын харилцах данснаас бүрдэнэ.

<sup>3</sup> М1 мөнгө нь банкнаас гадуурх мөнгө, банкуудын төгрөгийн харилцах данснаас бүрдэнэ.

78.8 тэрбум төгрөг, өмнөх сараас 12.5 хувь буюу 50.4 тэрбум төгрөгөөр өсч 452.8 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд төгрөгийн ханш суларснаас иргэд төгрөгөө валют руу хөрвүүлэх болсон явдал нөлөөлжээ.

Зураг 3. Нийт хадгаламж /жилийн өсөлт/



#### Бага мөнгө

Бага мөнгө (M1) өмнөх оны мөн үеэс 11.9 хувь буюу 70.1 тэрбум төгрөг, өмнөх сараас 20.5 хувь буюу 112.3 тэрбум төгрөгөөр тус тус өсч 660.6 тэрбум төгрөг болов. Тайлант сард төгрөгийн харилцахын үлдэгдэл 46.6 тэрбум төгрөг, банкнаас гадуурх мөнгө 65.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь бага мөнгөний өсөлтөд нөлөөлжээ. Бага мөнгөний өсөлтийн хурд 2007 оны мөн үеийнхээс 66.0 нэгжээр саарсан байна.

Тайлант онд төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 8.1 хувь буюу 24.7 тэрбум төгрөг, өмнөх сараас 16.3 хувь буюу 46.6 тэрбум төгрөгөөр өсч 331.9 тэрбум төгрөгт, гадаад валютын харилцах 11.6 хувь буюу 37.1 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 1.7 хувь буюу 4.8 тэрбум төгрөгөөр буурч 284.0 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Хүснэгт 2. Мөнгөний үзүүлэлт /жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг, сүүлийн 12 сарын өөрчлөлт, %/

|                        | 2001         | 2002         | 2003         | 2004         | 2005          | 2006          | 2007          | 2008          |
|------------------------|--------------|--------------|--------------|--------------|---------------|---------------|---------------|---------------|
| Нөөц мөнгө-M0          | 143.8        | 175.3        | 200.8        | 234.9        | 281.2         | 381.8         | 535.0         | 633.2         |
|                        | 8.2%         | 21.9%        | 14.5%        | 17.0%        | 19.7%         | 35.8%         | 40.1%         | 18.4%         |
| <b>Нийт мөнгө-M2</b>   | <b>331.1</b> | <b>470.1</b> | <b>703.3</b> | <b>847.0</b> | <b>1140.1</b> | <b>1536.5</b> | <b>2401.2</b> | <b>2341.4</b> |
|                        | 44.0%        | 42.0%        | 49.6%        | 20.4%        | 34.6%         | 34.8%         | 56.3%         | -2.5%         |
| <b>Бага мөнгө -M1</b>  | <b>156.2</b> | <b>187.7</b> | <b>212.8</b> | <b>221.3</b> | <b>269.1</b>  | <b>331.9</b>  | <b>590.5</b>  | <b>660.6</b>  |
|                        | 19.4%        | 20.2%        | 13.4%        | 4.0%         | 21.6%         | 23.3%         | 77.9%         | 11.9%         |
| Банкнаас гадуурх мөнгө | 109.2        | 120.8        | 131.5        | 143.5        | 152.4         | 185.1         | 283.3         | 328.7         |
|                        | 8.2%         | 10.6%        | 8.9%         | 9.1%         | 6.2%          | 21.5%         | 53.0%         | 16.0%         |
| Төгрөгийн харилцах     | 47.0         | 66.9         | 81.3         | 77.8         | 116.8         | 146.8         | 307.1         | 331.9         |
|                        | 57.5%        | 42.5%        | 21.5%        | -4.3%        | 50.0%         | 25.7%         | 109.3%        | 8.1%          |
| <b>Бараг мөнгө</b>     | <b>174.9</b> | <b>282.4</b> | <b>490.5</b> | <b>625.7</b> | <b>871.0</b>  | <b>1204.6</b> | <b>1810.8</b> | <b>1680.8</b> |
|                        | 76.4%        | 61.5%        | 73.7%        | 27.6%        | 39.2%         | 38.3%         | 50.3%         | -7.2%         |
| <b>Нийт хадгаламж</b>  | <b>134.6</b> | <b>218.4</b> | <b>363.5</b> | <b>517.4</b> | <b>671.7</b>  | <b>995.4</b>  | <b>1489.7</b> | <b>1396.9</b> |
|                        | 111.1%       | 62.2%        | 66.5%        | 42.3%        | 29.8%         | 48.2%         | 49.7%         | -6.2%         |
| Төгрөгийн хадгаламж    | 87.6         | 147.2        | 240.3        | 301.0        | 426.0         | 692.5         | 1113.7        | 944.1         |
|                        | 48.4%        | 68.1%        | 63.2%        | 25.3%        | 41.6%         | 62.5%         | 60.8%         | -15.2%        |
| Валютын хадгаламж      | 47.0         | 71.1         | 123.3        | 216.4        | 245.7         | 302.9         | 376.0         | 452.8         |
|                        | 39.6%        | 51.3%        | 73.2%        | 75.6%        | 13.5%         | 23.3%         | 24.1%         | 20.4%         |
| Валютын харилцах       | 40.3         | 64.0         | 127.0        | 108.3        | 199.3         | 209.2         | 321.1         | 284.0         |
|                        | 13.9%        | 58.9%        | 98.3%        | -14.7%       | 84.0%         | 5.0%          | 53.5%         | -11.6%        |

Банкнаас гадуурх мөнгө гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 80.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх сараас 1.3 нэгж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 нэгжээр их байлаа. Мөн банкнаас гадуурх мөнгө М2-ийн харьцаа 14.0 хувь болсон нь өмнөх сараас 2.3 нэгж, өнгөрсөн оны мөн үеэс 2.2 нэгжээр тус тус их байна.


### Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх оны мөн үеэс 18.4 хувь (98.2 тэрбум төгрөг), өмнөх сараас 29.0 хувь (142.2 тэрбум төгрөг)-аар тус тус өсч 633.2 тэрбум төгрөгт хүрчээ. Тайлант сард банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн үлдэгдэл 41.2 хувь буюу 65.9 тэрбум төгрөг, банкуудын касс 15.5 хувь буюу 10.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөөц мөнгийг өсгөлөө.

### 2.2 Гадаад, дотоод цэвэр актив

Тайлант сард гадаад цэвэр актив өмнөх оны мөн үеийнхээс 52.8 хувь буюу 759.0 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх сараас 2.8 хувь буюу 18.5 тэрбум төгрөгөөр өсч 677.1 тэрбум төгрөгт, дотоод цэвэр актив өмнөх оны мөн үеэс 72.5 хувь буюу 699.4 тэрбум төгрөг, өмнөх сараас 5.1 хувь буюу 81.1 тэрбум төгрөгөөр өсч 1664.3 тэрбум төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл нийт мөнгөний 28.9 хувь нь гадаад цэвэр активт, 71.1 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Зураг 4. Гадаад, дотоод цэвэр актив



### Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц 2008 оны 12 дугаар сарын байдлаар 637.2 сая ам. доллар байж, импортын 9.2 долоо хоног буюу 2.3 сарын төлбөртэй дүйцэхүйц байна. Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 34.7 хувь буюу 338.1 сая ам. доллараар буурч, өмнөх сараас 5.1 хувь буюу 30.9 сая ам. доллараар өсчээ. Төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоодын зах зээлд валют нийлүүлсэн нь гадаад цэвэр албан нөөц бууралтад нөлөөлсөн.

Зураг 5. Гадаад валютын цэвэр албан нөөц, сая ам. доллар



### Зээл


Дотоод цэвэр активын гол бүрэлдэхүүн болох банкны салбараас олгосон зээл тайлант сарын эцэст 2635.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 579.5 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 32.6 тэрбум төгрөг буюу 1.2 хувиар буурчээ. Зээлийн өрийн үлдэгдлийн өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 39.9 нэгжээр саарсан нь эх үүсвэр (хадгаламж, харилцах) буурсантай холбоотой байна. Банкуудаас хувийн хэвшилд олгосон зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 34.7 хувиар өсч 1570.4 тэрбум төгрөг, иргэдэд олгосон зээл 20.9 хувиар өсч 1013.7 тэрбум төгрөг, улсын салбарт олгосон зээл 27.3 хувиар өсч 34.8 тэрбум төгрөг, бусад байгууллагад олгосон зээл 30.0 хувиар буурч 16.7 тэрбум төгрөгт тус тус хүрэв. Тайлант жилд төгрөгөөр олгосон зээл өмнөх оны мөн үеэс 28.5 хувь буюу 366.6 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 1.5 хувь буюу 27.6 тэрбум төгрөгөөр буурч 1785.5 тэрбум төгрөгт, валютаар олгосон зээл өмнөх оны мөн үеэс 33.4 хувь буюу 212.9 тэрбум төгрөгөөр өсч, өмнөх сараас 0.6 хувь буюу 4.9 тэрбум төгрөгөөр буурч 850.0 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Хүснэгт 3. Зээл, зээлийн хүү /жил бүрийн 12 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг/

|                          | 2002  | 2003  | 2004  | 2005  | 2006    | 2007    | 2008    |
|--------------------------|-------|-------|-------|-------|---------|---------|---------|
| Зээл                     | 231.4 | 442.1 | 606.8 | 859.9 | 1,223.3 | 2,056.1 | 2,635.6 |
|                          | 71.4% | 91.0% | 37.2% | 41.7% | 42.3%   | 68.1%   | 28.2%   |
| Төгрөгийн зээлийн хүү, % | 33.4  | 31.5  | 30.0  | 28.3  | 24.5    | 19.9    | 20.4    |
| өөрчлөлт /нэгж/          | -5.6  | -1.9  | -1.5  | -1.7  | -3.8    | -4.6    | 0.5     |
| Валютын зээлийн хүү, %   | 19.8  | 19.6  | 17.9  | 14.8  | 15.5    | 14.2    | 16.8    |
| өөрчлөлт /нэгж/          | -2.4  | -0.2  | -1.7  | -3.1  | 0.7     | -1.3    | 2.6     |

Нийт зээлийн үлдэгдлийн 89.3 хувийг хэвийн зээл, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 7.2 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувийн жин өнгөрсөн оны мөн үеэс 3.9 нэгжээр өсчээ.

Зураг 6. Зээлийн өрийн үлдэгдэл




Харин өмчлөгчөөр нь авч үзвэл нийт зээлийн 59.6 хувь нь хувийн хэвшил, 38.5 хувь нь иргэд, 1.3 хувь нь улсын байгууллага, 0.6 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна. ХААН, Худалдаа хөгжил, Голомт банкууд нийт зээлийн 56.3 хувийг олгожээ.

### Зээлийн хүү

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 4.9 нэгжээр өсч жилийн 14.78 хувь болов. Банк хоорондын захын хүү тайлант сард 17.87 хувь болсон нь өмнөх оны мөн үеэс 9.6 нэгжээр өссөн байна.

Зураг 7. ТБҮЦ, банк хоорондын захын болон зээлийн хүү /жилээр, хувиар/



Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү<sup>4</sup> өмнөх сарынхаас 1.9 нэгж, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгжээр өсч жилийн 20.4 хувьд, валютынх өмнөх сарынхаас 0.8 нэгж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.6 нэгжээр тус тус өсч жилийн 16.8 хувьд хүрчээ. Тайлант сард банкуудаас төгрөгөөр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү

6.0-27.1 хувь, валютаар олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 7.8-27.7 хувийн хооронд хэлбэлзэж байв.

### 3. Мөнгөний зах зээл

Тайлант сард банк хоорондын захын арилжаагаар нийт 323.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн бөгөөд үүний 68.3 хувь нь овернайт зээл, 22.9 хувь нь банк хоорондын хадгаламж, 8.8 хувь нь банк хоорондын зээл байв. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 17.87 хувь байлаа.

2008 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2008 оны 12 дүгээр сарын 30-ний өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөнд 79.5 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөнд 48.0 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөнд 111.9 тэрбум төгрөг, валютын нөөцөнд 75.3 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### 4. Валютын ханш

Төгрөгийн америк доллартай харьцах ханш 2008 оны 12 дугаар сарын эцэст 1267.5 төгрөг болж, өмнөх сарынхаас 96.9 төгрөг буюу 8.3 хувь, өмнөх оны мөн үеэс 97.5 төгрөг буюу 8.3 хувиар тус тус суларчээ.

Зураг 8. Америк доллартай харьцах төгрөгийн ханш



**МОНГОЛБАНК**

<sup>4</sup> Зарласан хүү